2019 оны 01 сарын 03-ны өдөр Дугаар А/09 Улаанбаатар хот

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд,
Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд,
орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын
2018 оны үйл ажиллагааны үр дүнг
үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны "Журам батлах тухай" А/335 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газар, орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Байгууллага, нэгжүүдийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 21-ний дотор зохион байгуулж, дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 01 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэхийг зохион байгуулах комисс /М.Отгонбаяр/-т даалгасугай.

3.Байгууллага, нэгжүүдийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, ажлын хуваарь гарган баталж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ,
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 03-ны өдрийн
А/09 дүгээр захирамжийн нэгдүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД,
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА ГАЗРУУДЫН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаяр
Гишүүд:	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Эрдэнэжаргал
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Э.Энхцэцэг
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаа
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Эрдэнэчимэг
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Гантулга

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 03-ны өдрийн
А/09 дүгээр захирамжийн хоёрдугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД, УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА ГАЗРУУДЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажил нь бүх шатанд ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэх, санаачилгыг өрнүүлэх замаар амжилтыг бататгах, хүндрэл бэрхшээлийг арилгаж иргэдэд үйлчлэх, төрийн ажил үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, бодлогын зорилтууд, тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангахад оршино.

Хоёр. Эрх зүйн үндэс: “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг баталсан Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоол болон “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баталсан нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг тус тус эрх зүйн үндэс болгоно.

Гурав. Чиглэл: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ дараах чиглэлүүдийг онцгойлон анхаарна. Үүнд:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал
- Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүн
- Дүүргийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нартай байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжүүлэх тухай гэрээ” болон нэгжүүдийн Ерөнхий менежерүүдтэй байгуулсан “Үр дүнгийн гэрээ”-ний биелэлт
- Байгууллагуудын дүрмээр хүлээсэн үүрэг, үндсэн үйл ажиллагаа, түүний бүтээмжийн байдал
- Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн давхардал, хийдэл, албан хаагчдын ажлын ачаалал, ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хэрэгжилт

- Төрийн албаны стандартын хэрэгжилт, төрийн албан хаагчийн томилгоо, хувийн хэргийн бүрдүүлэлт, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, түүний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал
- Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг хөгжүүлэх сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартын хэрэгжилт /баримт бичгийн нэр, томьёо, үг хэллэг, утга найруулга, монгол хэл бичгийн дүрмийн шаардлага хангасан байдал, баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавигдах шаардлага/
- Өмнөх жилийн ажлын үр дүнг үнэлсэн ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний гүйцэтгэл
- Нийслэлийн удирдлагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл
- Байгууллага, нэгжүүдийн удирдлагын харилцаа, хандлага, мэргэжлийн ур чадвар, удирдлагын манлайлал
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн
- Нийслэлийн Засаг даргын “Ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/1034 дугаар захирамжийн дагуу холбогдох үзүүлэлтийг тооцож, хэрэгжилтийг хангасан байдал
- Улаанбаатар хотын “Аз жаргалтай хотын индекс”, байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ийг тооцох аргачлалын дагуу дүгнэсэн байдал
- Салбарын хэмжээнд, байгууллагын түвшинд шинэ ажил, санаачилга гарган зохион байгуулах төлөвлөсөн ажил
- Мэдээллийн ил тод байдлыг холбогдох хууль, тогтоол, захирамжийн дагуу хангуулан ажилласан байдал

Дөрөв. Хамрагдах байгууллага, нэгжүүд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/-үүд, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд хамрагдана.

Тав. Хугацаа: Үнэлгээний ажлын хэсгүүд 2019 оны 01 дүгээр сарын 07-оос 21-ний өдрүүдэд байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан батлагдсан хуваарийн дагуу ажлын 10 хоногт багтаан нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Зургаа. Зохион байгуулалт: Үүнд:

1. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгүүд нь тайлан, дүгнэлтээ нэгтгэн нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

2. Тухайн байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллана.

3. Байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүн, дүгнэлт зөвлөмжийг ажлын хэсэг багаар хэлэлцэн гаргах бөгөөд дүгнэлтэд ажлын хэсгийн ахлагч болон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

4. Дүгнэлтийн бодит байдлыг тухайн ажлын хэсэг хариуцна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгүүд шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахдаа байгууллага, нэгжүүдийн тухайн жилд хийсэн ажлын ололт амжилт, алдаа дутагдал, анхаарах зүйлс, цаашид авч хэрэгжүүлэх ажлуудын талаар илтгэх хуудсандаа тусгана.

Долоо: Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/-үүд, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

7.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/-үүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Болдбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

Ажлын хэсгийн гишүүд:

Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
Б.Төгслхам	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Баялагцэнгэл	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Энхмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн ахлах мэргэжилтэн
Э.Батжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Мягмарсүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Л.Баттогтох	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

О.Мөнх-Оргил	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

7.2.Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Ү.Ганболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Алтанцэцэг	Нийслэлийн Төрийн албаны салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга
Б.Эрдэнэчимэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Д.Анхбаяр	Нийслэлийн Архивын газрын Захиргааны албаны дарга
Г.Гүррагчаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Б.Ууганжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
С.Сүхболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Д.Ганбат	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Р.Ягаанцэцэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Ц.Нямдэлгэр	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Г.Саянболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Сайнхүү	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

7.3.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Гантулга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Б.Ууганбат	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга
Д.Оюунгэрэл	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Норжинлхам	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Д.Цэрэндэжид	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

С.Ариунцэцэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Жавзмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Д.Мөнгөндуулга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
Н.Оргилболд	Нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн, Улсын байцаагч

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

О.Мандах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

7.4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Эрдэнэжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Ц.Ижилмөрөн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ч.Урантуяа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн мэргэжилтэн
Б.Бадамжав	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Баяржаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Ц.Ганцэцэг	Нийслэлийн Архивын газрын Лавлагаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Мишигдорж	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

7.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Даваажаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Э.Баясгалан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Ё.Баясгалан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
С.Билгүүн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн мэргэжилтэн
Ю.Дуламрагчаа	Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

О.Тунгалаг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

Найм: Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын шалгуур үзүүлэлт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/-үүд, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын шалгуур үзүүлэлт:

8.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны хэлтэс /нэгж/-үүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын шалгуур үзүүлэлт

Хүрээ	№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ (Үнэлгээ 50 %)	1.1	Хууль тогтоомж, шийдвэрт нийслэл /тухайн хэлтэс, нэгж/ хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт *(Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 01 дүгээр хавсралтад заасан аргачлалаар тооцно)*	0-100%
	1.2	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийслэл /тухайн хэлтэс, нэгж/ хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал, ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн *(Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 03, 04 дүгээр хавсралтад заасан аргачлалаар тооцно)*	0-100%
	1.3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал, ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн *(Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 02 дугаар хавсралтад заасан аргачлалаар тооцно)*	0-100%
	1.4	Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, чанар, үр дүн	0-100%
	Хэсгийн дундаж хувь		**0-100%**
	2.1	Хэлтэс, нэгжийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, үр дүн	0-100%
	2.2	Хэлтэс, нэгжийн дүрмээр хүлээсэн чиг үүрэг нь албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгагдсан байдал, хэрэгжилт	0-100%

Байгууллага, нэгжийн чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ (Үнэлгээ 40 %)	2.3	Хэлтэс, нэгжийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн Засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн	0-100%
	2.4	Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал, програм хангамжийн ашиглалт, хэрэглээ	0-100%
	2.5	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал, шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, програм хангамжийн ашиглалт, хэрэглээ	0-100%
	Хэсгийн дундаж хувь		**0-100%**
Ил тод байдлын үнэлгээ (Үнэлгээ 10%)	3.1	Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх эрх олгосон бол тухайн төрийн бус байгууллагын талаарх мэдээлэл, тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг ил тод байршуулсан байдал, мэдээллийн баяжилт, шинэчлэлт	0-100%
	3.2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгасан байдал	0-100%
	3.3	Хэлтэс, нэгжээс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал, үйлчилгээ үзүүлэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал	0-100%
	Хэсгийн дундаж хувь		**0-100%**
Ерөнхий үнэлгээ			**0-100%**

8.2. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-д заасан үлгэрчилсэн загвар шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР